

МОНГОЛ УЛСЫН ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН ДОТООД АУДИТЫН ХОРООНЫ ТОГТООЛ

2017 оны 02 дугаар
сарын 24-ний өдөр

Дугаар 02

Улаанбаатар
хот

“Мал эмнэлгийн эмийн сорилт, баталгаажуулалтын улсын лаборатори” ААТТӨҮГ-ын үйл ажиллагаанд хийсэн дотоод аудитын тайланг хэлэлцсэн тухай

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2017 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн А/06 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг “Мал эмнэлгийн эмийн сорилт, баталгаажуулалтын улсын лаборатори ААТТӨҮГ”-ын үйл ажиллагаанд хийсэн дотоод аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийг танилцуулав.

Мал эмнэлгийн эмийн сорилт, баталгаажуулалтын улсын лабораторийн санхүү бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийхэд Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай, Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай хуулиудын холбогдох заалтуудыг болон санхүү, төсвийн холбогдолтой гаргасан зарим тушаал, дүрэм, журмыг хэрэгжүүлээгүй, дагаж мөрдөөгүй дараах зөрчил дутагдлууд илэрсэн байна. Үүнд:

1. Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай хуулийн хүрээнд:

Өмнөх 2013 онд хийгдсэн дотоод аудитын зөвлөмжийн хүрээнд тус байгууллагын сорилтын болон баталгаажуулалтын лабораторийг итгэмжлүүлэхээр заасныг бүрэн хэрэгжүүлээгүй нь Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2 дах заалт “Нийтийн ашиг сонирхол, хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчин, улс орны аюулгүй байдалд хохирол учруулж болзошгүй бүтээгдэхүүний сорилтын лаборатори, баталгаажуулалт, техникийн хяналт явуулах байгууллага нь заавал итгэмжлэгдэнэ” гэснийг зөрчиж, итгэмжлэлгүйгээр үйл ажиллагаагаа хэрэгжүүлсэн зөрчил гаргасан.

2. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн хүрээнд:

- Тус байгууллагын санхүүгийн баримт бичгийн архивлалт хангалтгүй, үйлдвэрлэлд ашиглагдаж буй бараа бүтээгдэхүүний худалдан авсан анхан шатны баримт бичгийн бүрдүүлэлт, гэрээ, хэлцэл, бараа хүлээн авсан актын иж бүрдэл хангалт, өмнөх 2013 оны дотоод аудитаар өгөгдсөн зөвлөмжийн Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3.1.3.“анхан шатны баримт” гэж ажил, гүйлгээ гарсныг нотолж бүрдүүлдэг гэрээ, нэхэмжлэх, төлбөр төлсөн баримт болон бусад нотолгоог; гэснийг бүрэн хэрэгжүүлээгүй хэвээр байна.

- Хөрөнгийн бүртгэлээс өмнөх 2013 оны дотоод аудитаар өгөгдсөн зөвлөмжийн дагуу суудлын Соната-2 маркийн автомашиныг худалдсан боловч бүртгэлээс зохих журмын дагуу хасалт хийх гэснийг хэрэгжүүлээгүй.

- Лабораторийн үйл ажиллагааны чадавхийг сайжруулах, малын эмийн чанарын баталгаажуулалтыг олон улсын стандартад нийцүүлэн явуулах шаардлагатай байгааг анхааран үзэж ХХАА-н яамнаас үнэ төлбөргүйгээр шилжүүлсэн 85,9 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг эргэлтийн хөрөнгөд бүртгэснийг үндсэн үйл ажиллагааны орлогод тооцон хуримтлагдсан ашиг, алдагдлыг бодитоор гаргах нөхцөлийг бүрдүүлээгүй.

- МЭЭСБУЛ-ын захирал нь Төрийн өмчийн хороотой 2016 оны 06 сарын 09-ний өдөр контрактын гэрээ байгуулсан бөгөөд энэхүү гэрээний 6.4. Захирлын албан үүргээ биелүүлэхэд шаардагдах ажлын байр, уналга, техник хэрэгслээр хангана. Үүрэн телефон хэрэглэх зардал, суудлын автомашины гүйлтийг тогтоохдоо Засгийн газар, Төрийн өмчийн хорооны тогтоосон лимитыг баримтална. Захирал ээлжийн амралтын хугацаанд албаны суудлын автомашин хэрэглэх бол жилийн лимитэд багтаан үйлчлүүлэх эрхтэй гэсэн болон Засгийн газрын 2016 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн 141 дүгээр тогтоолыг зөрчиж 1,996,000.0 төгрөгийн үнэ бүхий гар утас худалдан авсан зөрчил гаргасан.

- Мөн 2016 оны Үндэсний аудитын дүгнэлтээр санхүүгийн жилийн эцсийн тайланд залруулга хийсэн бөгөөд ХХОАТ-ын тооцооллын алдаанаас гарсан зөрүү 18,335.6 төгрөгийг хувь хүнээс авах авлагаар бүртгэх зэрэг тус байгууллагын санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой зөрчил дутагдлууд тогтоогдсон.

3. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хүрээнд:

- Санхүүгийн 2015, 2016 оны тайлан, харилцахын баримтыг хянан үзэхэд тус байгууллагын үндсэн үйл ажиллагаанд хэрэглэгддэг бараа бүтээгдэхүүнийг худалдан авахдаа 10,0 сая төгрөгөөс доош худалдан авалт хийж буй шалтгаанаар гэрээ, хэлцэл, үнийн санал аваагүй нь 3.1.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авахад энэ хуулийг дагаж мөрдөнө гэснийг хэрэгжүүлээгүй.

- Байгууллагын сантехникийн засварын ажлын төсвийг Д.Энхтунгалаг зохиосон байх бөгөөд Д.Энхтунгалаг өөрөө ЭЛКОМ ХХК-ны захирал бөгөөд уг ажлыг гүйцэтгэсэн, уг ажлыг хүлээн авсан акттай боловч энэхүү үйл ажиллагаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дараах заалтуудыг зөрчсөн.

➤ 34.2. Энэ хуулийн 34.1-д заасан нөхцөлийн дагуу шууд гэрээ байгуулахад захиалагч энэ хуулийн 14-16 дугаар зүйлийн шаардлагыг хангасан, тухайн бараа, ажил, үйлчилгээг гүйцэтгэх чадавхитай нэг, эсхүл түүнээс дээш тооны этгээдтэй хэлэлцээ хийж, техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл, шаардлагыг хамгийн сайн хангасан этгээдтэй энэ хуульд заасны дагуу гэрээ байгуулах бөгөөд хэлэлцээний үед хүрсэн аливаа тохиролцоог гэрээнд тусгана.

➤ 7.1.3. Зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгч сонгох журам.

➤ 7.2.Хуульд энэ хуулийн 7.1.2-7.1.4-т заасан журмыг хэрэглэхээр зааснаас бусад тохиолдолд нээлттэй тендер шалгаруулалтын журмыг мөрдөнө.

➤ 8.1.3.Зөвлөх сонгох бага үнийн аргыг хэрэглэж болох зөвлөх үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар;

➤ 14.1.Дараах нөхцөл байдал тогтоогдвол тендерт оролцогч ерөнхий нөхцөл хангаагүй гэж үзнэ:

➤ 14.1.5.Тендерт оролцогч нь бараа, ажил, үйлчилгээний зураг төсөл, техникийн тодорхойлолт болон бусад баримт бичгийг бэлтгэсэн, эсхүл гэрээний хэрэгжилтийг хянах, зөвлөх үйлчилгээ үзүүлэхээр нэр нь дэвшигдсэн этгээдтэй нэгдмэл сонирхолтой; гэснийг тус тус хэрэгжүүлээгүйг тогтоов.

4. Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн хүрээнд:

Тус байгууллагын нягтлан бодогч Г.Бадамханд нь Цалин ба түүнтэй адилтгах орлогоос суутгах татварын хэмжээг санхүүгийн программд найдан дотоод хяналтыг хэрэгжүүлээгүйгээс 2014 онд 156,042.06 төгрөг, 2015 онд 122,761.77 төгрөг, нийт 278,803.83 төгрөгийн хувь хүний орлогын албан татварыг дутуу тооцсон нь дараах заалтуудыг зөрчсөн байна. Үүнд:

- 15.1.1. Үнэ төлбөргүй, эсхүл хөнгөлөлттэй үнээр тээврийн хэрэгслээр үйлчилсэн, түүнчлэн бэлнээр олгосон унааны мөнгө;
- 15.1.3. бэлнээр олгосон хоолны мөнгө, түүнчлэн үзвэр үйлчилгээний олговор;
- 23.1. Энэ хуулийн 17-19 дүгээр зүйл, 20.1.2-20.1.5, 22.1.4-т зааснаар тодорхойлсон орлогын жилийн дүнд 10 хувиар тооцож албан татвар ногдуулна.
- 22.1.4. Шууд бус орлогод ногдуулах албан татварыг тухайн орлогын дүнгээр. гэснийг тус тус зөрчиж байгаа ба тус байгууллагын программ хангамж нь нягтлан бодох бүртгэлийн зарим хууль, дүрэм, журам, стандартыг бүрэн тусгаагүй, нягтлан бодогч программын үнэн зөв бүртгэлд дотоод хяналтыг хэрэгжүүлээгүй байна.

5. Шилэн дансны тухай хуулийн хүрээнд:

Тус байгууллагын 2017 оны эхний улирлын санхүүгийн үйл ажиллагааны хэрэгжилт, шилэн дансны мэдээлэл оруулж буй байдалд хяналт хийхэд тус хуулийн 5,0 сая төгрөгөөс дээш худалдан авсан бараа ажил үйлчилгээг бүрэн оруулсан боловч 5,0 сая төгрөгөөс бага үнийн дүнтэй худалдан авсан бараа ажил үйлчилгээний мэдээллийг бүрэн оруулаагүй нь Засгийн газрын 2014 оны 384 дүгээр тогтоол “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам”-ын 3.4.5. дугаар заалт Байгууллага:

- Хандив, тусламжийн хэмжээ, түүний зарцуулалт
- Байгууллагын өмч хөрөнгө, мөнгө зарцуулах, өр авлага, зарлага, худалдан авах үйл ажиллагаатай холбоотой шийдвэр
- Нийгмийн даатгалын сангаас олгосон тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн талаарх мэдээлэл гэснийг хэрэгжүүлээгүй байна.

Дотоод аудитын дүгнэлт, дотоод аудитаар илэрсэн зөрчил дутагдлын талаар хэлэлцээд Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.3, Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор батлагдсан Дотоод аудитын дүрмийн 2.1 дэх заалтыг тус тус үндэслэн

ТОГТООХ нь:

1. Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2 дах заалт “Нийтийн ашиг сонирхол, хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчин, улс орны аюулгүй байдалд хохирол учруулж болзошгүй бүтээгдэхүүний сорилтын лаборатори, баталгаажуулалт, техникийн хяналт явуулах байгууллага нь заавал итгэмжлэгдэнэ” гэснийг мөрдөж ажиллаж Мал эмнэлгийн эмийн сорилт, баталгаажуулалтын улсын лабораторийн сорилтын болон баталгаажуулалтын лабораторийн итгэмжлэлийн хугацааг 2017 оны эхний хагас жилд багтаан сунгуулах арга хэмжээ авахыг МЭЭСБУЛ ААТТӨҮГ-ын захирал /Д.Ууганбаяр/-д үүрэг болгосугай.

2. Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2 дах заалт “Нийтийн ашиг сонирхол, хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчин, улс орны аюулгүй байдалд хохирол учруулж болзошгүй бүтээгдэхүүний сорилтын лаборатори, баталгаажуулалт, техникийн хяналт явуулах байгууллага нь заавал итгэмжлэгдэнэ” гэснийг зөрчсөн, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх заалт, 7 дугаар зүйлийн 7.1.3, 7.2 дах заалтууд, 8 дугаар зүйлийн 8.1.3 дах заалт, 14 дүгээр зүйлийн 14.1, 14.1.5 дах заалтууд, 34 дүгээр зүйлийн 34.2 дах заалт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3, 5.1.4 дэх заалтууд, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1, 15.1.3 дах заалтууд, 22 дугаар зүйлийн 22.1.4 дэх заалт, 23 дугаар зүйлийн 23.1 дэх заалт, Засгийн газрын 2014 оны 384 дүгээр тогтоол “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам”-ын 3.4.5 дугаар заалтуудыг тус тус хэрэгжүүлээгүй зөрчил гаргасан.

Мөн Мал эмнэлгийн эмийн сорилт, баталгаажуулалтын улсын лабораторийн захирал нь Төрийн өмчийн хороотой 2016 оны 06 сарын 09-ний өдөр байгуулсан гэрээний 6.4 дэх заалт, Засгийн газрын 2016 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн 141 дүгээр тогтоолыг мөрдөж ажиллаагүй зэрэг зөрчил дутагдлуудад дотоод хяналт тавьж ажиллаагүй байгууллагын удирдлагад хариуцлага тооцох асуудлыг судалж шийдвэрлэхийг Төрийн захиргаа удирдлагын газрын дарга /М.Мөнхбаясгалан/-д үүрэг болгосугай.

3. Мал эмнэлгийн эмийн сорилт, баталгаажуулалтын улсын лабораторийн санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой гарсан асуудлуудыг дүгнэлт, зөвлөмжид тусгаснаар холбогдох хууль, тогтоомж, дүрэм, журмуудад нийцүүлэн хариу арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан 2017 оны 5 дугаар сарын 12-ны өдрийн дотор Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт ирүүлэхийг МЭЭСБУЛ ААТТӨҮГ-ын захирал /Д.Ууганбаяр/-д үүрэг болгосугай.

4. Хариу арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг хяналтад авч, биелэлтийг дотоод аудитын хороонд тайлагнахыг Хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга /Д.Совд/-д үүрэг болгосугай.

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН
ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ,
ДОТООД АУДИТЫН ХОРООНЫ ДАРГА

П.СЭРГЭЛЭН

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны
Дотоод аудитын хорооны 2017 оны 02 дугаар сарын
24-ны өдрийн 02 дугаар тогтоолын хавсралт

МАЛ ЭМНЭЛГИЙН ЭМИЙН СОРИЛТ, БАТАЛГААЖУУЛАЛТЫН УЛСЫН ЛАБОРАТОРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮНГ ДЭЭШЛҮҮЛЭХ ТАЛААР ГАРГАСАН ЗӨВЛӨМЖ

“Мал эмнэлгийн эмийн сорилт, баталгаажуулалтын улсын лаборатори” ААТТӨҮГ-ын санхүүгийн үйл ажиллагаанд гүйцэтгэсэн дотоод аудитын үр дүн, илэрсэн зөрчил, дүгнэлтийг үндэслэн дараах зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

1. Үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй байгаа 4.3 сая төгрөгийн үнэ бүхий “Соната-2” маркийн автомашины төлбөрийн асуудлыг шүүх хяналтын байгууллагаар шийдвэрлүүлж, ТӨХ-ны тогтоол гаргуулан байгууллагын үндсэн хөрөнгийн бүртгэлээс хасуулах.

2. Тус байгууллагын албан хаагчдын цалин ба түүнтэй адилтгах орлогын шууд бус орлого болох хоол, унааны зардлаас Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 15.1.1, 23.1, 22.1.4 дүгээр заалтуудыг үндэслэн 2014-2015 онуудад дутуу суутгасан нийт 278,803.83 төгрөгийг холбогдох албан хаагчдын цалингаас суутгаж улсын төсөвт төвлөрүүлэх. (Улсын ахлах байцаагчийн акт)

3. “МЭЭСБУЛ” ААТТӨҮГ-ын захиралтай байгуулах контракт /гэрээ/ -ний 6.4 Захирлын албан үүргээ биелүүлэхэд шаардагдах ажлын байр, уналга, техник хэрэгслээр хангана. Үүрэн телефон хэрэглэх зардал, суудлын автомашины гүйлтийг тогтоохдоо Засгийн газар, Төрийн өмчийн хорооноос тогтоосон лимитыг баримтлана. Захирал ээлжийн амралтын хугацаанд албаны суудлын автомашин хэрэглэх бол жилийн лимитэд багтаан үйлчлүүлэх эрхтэй гэсэн болон Засгийн газрын 2016 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн 141 дүгээр тогтоолд зааснаар 1,996,000.0 төгрөгийн үнэ бүхий гар утасны төлбөрийг эргэлтийн хөрөнгийн бүртгэлээс хасч, эд хөрөнгө хариуцагчийн өглөгөөр бүртгэн байгууллагын төсөвт төвлөрүүлэх. (Улсын ахлах байцаагчийн акт, албан шаардлага)

4. Санхүүгийн 2016 оны тайланд тусгагдаагүй ХХАОАТ-ын тооцооллын алдаа болох 18335,6 төгрөгийг хувь хүний авлагаар 15 дугаар зүйл. Нягтлан бодох бүртгэлийн алдааг залруулан бүртгэх. (Улсын байцаагчийн албан шаардлага)

- 15.1.Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэл хөтлөлтөд гарсан алдааг алдаа гарсан шалтгаан, залруулах аргыг тодорхой тусгасан баримт, тайланг үндэслэн залруулах бөгөөд зөвшөөрсөн болон залруулга хийсэн албан тушаалтан гарын үсэг зурж баталгаажуулна.

- 15.2.Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна.

5. Байгууллагын хэвийн ажиллагааг хангах зорилгоор худалдан авч буй аливаа бараа, ажил, үйлчилгээг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хүрээнд гүйцэтгэж, энэ хуулийг дагаж мөрдөх.

6. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3.1.3.“анхан шатны баримт” гэж ажил, гүйлгээ гарсныг нотолж бүрдүүлдэг гэрээ, нэхэмжлэх, төлбөр төлсөн баримт болон бусад нотолгоог; мөн 7.1. “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.” гэсэн заалтыг бүрэн хэрэгжүүлэх.

7. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах, Засгийн газрын 2014 оны 384 дүгээр тогтоол “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам”-ын 3.4.5. дугаар заалт Байгууллага:

- Хандив, тусламжийн хэмжээ, түүний зарцуулалт

- Байгууллагын өмч хөрөнгө, мөнгө зарцуулах, өр авлага, зарлага, худалдан авах үйл ажиллагаатай холбоотой шийдвэр

- Нийгмийн даатгалын сангаас олгосон тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн талаарх мэдээлэл гэснийг хэрэгжүүлэх

8. Дотоод аудитын хорооны тогтоолын хэрэгжилтийг хангах, хариу арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан энэхүү тогтоол хүлээн авсан өдрөөс хойш ажлын 10 хоногийн дотор ХХААХҮЯ-ны ХШҮДАГ-г ирүүлэхийг тус тус зөвлөж байна.